



Монголын нийгмийн эрүүл мэндийн
мэргэжилтнүүдийн нийгэмлэг



БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ ХАЯГ

Монголын нийгмийн эрүүл мэндийн
мэргэжилтнүүдийн нийгэмлэг
Утас/Факс: 976-11-325190
E-майл: mphpa.mongolia@gmail.com
Вебсайт: <http://www.mphpa.com>

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ОНОЛ ПРАКТИКИЙН АНХДУГААР
БАГА ХУРАЛ**

“Хамтран ажиллаж, суралцан ухуулан
таниулах замаар нийгмийн эрүүл мэндийг
шинэ түвшинд хөгжүүлэх нь”

**МНЭММН нь Нийгмийн эрүүл мэндийн онол
практикийн анхдугаар бага хурлыг 2011 оны
12 сарын 08-нд зохион байгуулах гэж байна.**

БАГА ХУРЛЫН ҮНДСЭН СЭДЭВ НЬ

ХАМТРАН АЖИЛЛАЖ СУРАЛЦАН, УХУУЛАН ТАНИУЛАХ ЗАМААР НИЙГМИЙН ЭРҮҮЛ ШИНЭ ТҮВШИНД ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Онол пракикийн бага хуралд илтгэл тавих төдийгүй оролцохыг хүссэн бүх хүмүүст оролцох боломжийг нээлттэй бүрдүүлж байна. МНЭММН нь онол практикийн бага хуралд тавих илтгэлийн хураангуйг хүлээн авч байна. Онол практикийн бага хурал дараах үндсэн 4 чиглэлд явагдана. Үүнд:

- **Бодлогын хэрэгжилт практикийн түвшинд**
- **Эрүүл мэндийн салбарын удирдлага, менежмент**
- **Эрүүл мэндийг дэмжих**
- **Хүрээлэн буй орчны эрүүл мэнд**

ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙН УДИРДАМЖ:

- Илтгэгчийн илтгэл болон хураангуйн сэдэв нь нийгмийн эрүүл мэндийн одоогийн болон тулгамдсан асуудлыг хөндсөн байдлыг илүүтэй дэмжих болно.
- Илтгэлийн хураангуй 250 үгнээс хэтрэхгүй байх ба илтгэлийг явуулахдаа үг, үсгийн болон дүрмийн алдааг шалгасан байх.
- Илтгэлийг онлайнаар буюу нийгэмлэгийн вебсайт (www.mphra.com), болон Емэйл хаягаар (mphra.mongolia@gmail.com) явуулна.
- Илтгэлийг явуулахдаа илтгэлийн тохирох хурлын чиглэлийг сонгоно уу. Хэрвээ нэгээс илүү зохиогч байвал илтгэлийг тавих хүний нэр, холбоо барих хаягийг бичнэ.
- Илтгэлийн хураангуйг дараах эцсийн хугацаанд багтаж ирүүлэхийг зөвлөж байна.
- Илтгэлийн хураангуйг илгээж буй нь таны хуралд илтгэл тавих ёстойг баталгаажуулж байгаа тул та хураангуйг илгээхийн өмнө үндсэн нөхцлүүдийг сайтар анхаарна уу.
- Энэхүү хуралд тавих хураангуй нь өмнө нь ямар нэг байдлаар танилцуулагдаж, хэвлэгдээгүй байх ёстой.

АНХААРАХ ЗҮЙЛ:

Илтгэлийн хураангуйг явуулж буй хүн заавал МНЭММН-ийн гишүүн байх шаардлагагүй. Хэдий тийм боловч оролцогч онол практикийн бага хуралд оролцохдоо доор заасан бүртгэлийн эцсийн хугацааны өмнө оролцох эсэхээ бүртгүүлэх ёстой.

ИЛТГЭЛИЙН УДИРДАМЖ

- Илтгэлийн хугацаа нь 15 минут байх бөгөөд, илтгэгч бүрт асуулт хариултын 5 минут байна.
- Power point ашиглах хүмүүст компьютер бусад тоног төхөөрөмж ашиглах боломжтой боловч, хурлын үеэр интернет ашиглах боломжгүйг анхаарна уу.

БҮРТГЭЛ

- Онол практикийн бага хуралд ороцогчид доорхи хугацаанд бүртгүүлнэ. Бүртгэлийг онлайнаар (www.mphra.com) эсвэл Емэйл хаягаар бүртгүүлнэ.
- Бүртгэлийн хураамж 10,000 төрөг буюу 10 доллар. Хураамжийн төлбөр нь онол практикийн бага хурлыг зохион байгуулахад хувь нэмэр болох юм.

ЧУХАЛ ХУГАЦААНУУД

- **Илтгэлийн товч хураангуйг хүлээн авах эцсийн хугацаа
2011 оны 11 сарын 10**
- **Бүртгэл дуусах эцсийн хугацаа:
2011 оны 11 сарын 25**
- **Илтгэгч нарт Е-мэйл хаягаар илтгэлтэй холбоотой
мэдээллийг анхааруулах эцсийн хугацаа:
2011 оны 11 сарын 15**
- **Илтгэл хүлээн авах эцсийн хугацаа:
2011 оны 12 сарын 01**
- **Онол практикийн анхдугаар бага хурал болох хугацаа:
2011 оны 12 сарын 08**